Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргы[illegible]2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ГАНХУЯГИЙН ТҮВШИНБАЯРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт Нэг. “Салбарын хэмжээнд шинээр болон, шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай хуулиудын үндэслэл, хэрэгцээ шаардлага үндэслэлийг боловсруулах, хуулийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх”, ”Хууль эрх зүйн баримт бичигт орж байгаа өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгын хууль зүйн үр дагавар, үр нөлөөний судалгаа шинжилгээ хийх ” ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** Салбарын хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг холбогдох хуулиар зохицуулахаар нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах. | Засгийн газрын хуралдааны 2023 оны 48 дугаар тэмдэглэлтийн хэрэгжилт хангагдсан байна. | 0% | Хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэн ХЗДХЯ-нд тогтоосон хугацаанд хүргүүлэх.. | Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 48 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэл болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/07 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, Хууль зүй дотоод хэргийн яамнаас ирүүлсэн захиргааны хэм хэмжээний акт гаргахаар хуулиар эрх олгосон зохицуулалтын судалгаа, эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэлтэй 91 шийдвэрт дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээний | 01-3 сар | 100 % |

85

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | саналыг боловсруулан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1а/854 тоот албан бичгээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | | |
| 2 | **Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах.** | **Хуулийн төслийн боловсруулалтын хувь.** | **30%** | **30%** | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн. Эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн үзэл баримтлалыг Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. | 02- 12 сар | **Нэгдсэн дүн 40%** |
| 3 | **Дэд арга хэмжээ 1.2.1.** Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 5% | 5% | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн. | 02-3 сар | 100% |
| 4 | **Дэд арга хэмжээ 1.2.2.** Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулж батлуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 5% | 5% | Эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн үзэл баримтлалын төслийг Хууль зүй дотоод хэргийн сайд болон Эрүүл мэндийн сайд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хамтран баталсан. Улсын Их Хурлаас 2024 оны 07 сарын 10-ны өдөр Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль батлагдсантай холбогдуулан Үзэл баримтлалын төслийг дахин боловсруулж батлуулахаар ажиллаж байна. | 3-5 сар | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5 | **Дэд арга хэмжээ 1.2.3.** Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагаж гарах хуулийн төсөл боловсруулах. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 10% | 20% | Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалын хүрээнд боловсруулалт хийгдэж байна. | 3-12 сар | 50% |
| 6 | **Дэд арга хэмжээ 1.2.4.** Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 0% | 10% | Эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг Эрүүл мэндийн яамнаас 2025-2028 онд багтаан УИХ-д өргөн мэдүүлэхээр Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгуулахаар ХЗДХЯ-нд санал хүргүүлж Засгийн газраар батлуулсан. Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулахаар ажиллаж байна. | 8-9 сар | 0% |
| 7 | **Дэд арга хэмжээ 1.2.5.** Хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авах. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 5% | 10% | | 6-7 сар | 0% |
| 8 | **Арга хэмжээ 1.3.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна.** | **Хуулийн төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь** | **40 %** | **60 %** | Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2024 оны 06 сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан. | 01-7 сар | **Нэгдсэн дүн 100%** |
| 9 | **Дэд арга хэмжээ 1.3.1.** Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 15 % | 35 % | Эм, эмнэлгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 10 бүлэг, 60 зүйл, 342 хэсэг, 436 заалт, 4 дэд заалттайгаар боловсруулан | 01-3 сар | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | түүнийг дагаж гарах хуулийн төслүүд эцэслэн боловсруулна. | | | | үүнтэй холбогдуулан 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 1а/1637 тоот албан Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. | | |
| 10 | **Дэд арга хэмжээ 1.3.2.** Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог шинэчлэн хийж, дэлгэрэнгүй танилцуулга бэлдэнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 15 % | 10 % | • Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан-19 хуудас<br>• Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан-27 хуудас<br>• Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн дэлгэрэнгүй танилцуулга-43 хуудас, 3 хуудас товч танилцуулга бэлтгэсэн. | 01-3 сар | 100% |
| 11 | **Дэд арга хэмжээ 1.3.3.** Хэлэлцүүлгүүд зохион байгуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 10 % | 10 % | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнийг дагаж гарах 13 хуулийн төсөлтэй холбоотой хэлэлцүүлгийг 2023-2024 онд нийт | 01-3 сар | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | 10 удаа зохион байгуулсан. Үүнээс 2024 онд 3 удаагийн хэлэлцүүлгийг Төрийн нарийн бичгийн дарга болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. | | |
| 12 | **Дэд арга хэмжээ 1.3.4.** Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас санал авна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 5 % | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнийг дагаж гарах 13 хуулийн төсөлд 19 яамд, Гаалийн ерөнхий газар, 4 мэргэжлийн төрийн бус байгууллага / Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "ЭМ" холбоо, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэг, Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбоо, Монголын эм хангамжийн байгууллагын холбоо/, Эрүүл мэндийн яамны цахим хуудсаар /60 хоног/ санал ирүүлсэн 3 байгууллага, 1 иргэний саналыг авч ажлын хэсгээр хэлэлцэж, үндэслэл бүхий саналыг тусгасан. | 01-3 сар | 100% |
| 13 | **Арга хэмжээ 1.4. Хүний генетикийн тухай хуулийн төсөл боловсруулах.** | **Хуулийн төслийн боловсруулалтын хувь.** | **20%** | **20%** | Хүний генетикийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 хавсралтын дагуу хийсэн. Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаанд үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. | **02-12 сар** | **Нэгдсэн дүн 40%** |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 14 | **Дэд арга хэмжээ 1.4.1.** Хүний генетикийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа хийх. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 5% | 5% | Хүний генетикийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 хавсралтын дагуу хийсэн. Хөрш улсууд болон Номхон далайн баруун эргийн бүс нутгийн бусад улсуудад мөрдөгдөж байгаа Хүний генетикийн чиглэлийн хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт, ололт, тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг цуглуулсан. | 4-6 сар | 100% |
| 15 | **Дэд арга хэмжээ 1.5.2.** Хүний генетикийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж батлуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 5% | 5% | Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаанд үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. | 5-6 сар | 100% |
| 16 | **Дэд арга хэмжээ 1.2.3.** Хүний генетикийн тухай хуулийн төсөл болон дагаж гарах хуулийн төсөл боловсруулах. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 10% | 10% | Хүний генетикийн тухай хуулийн төслийг Эрүүл мэндийн яамнаас 2025-2028 онд багтаан УИХ-д өргөн мэдүүлэхээр Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгуулахаар ХЗДХЯ-нд санал хүргүүлж Засгийн газраар батлуулсан. | 3-6 сар | 0% |
| 17 | **Дэд арга хэмжээ 1.2.4.** Хүний генетикийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 0% | 10% | | 8-9 сар | 0% |
| 18 | **Дэд арга хэмжээ 1.2.5.** Хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 0% | 10% | | 8-12 сар | 0% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | салбар зөвлөлөөс санал авах. | | | | | | |

**Хоёр.Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан Засгийн газар болон УИХ-д өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангах. | Батлагдсан үзэл баримтлал<br><br>ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 0% | Үзэл баримтлал батлагдсан байна.<br><br>Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангаж Засгийн газар, Нийгмийн бодлогын байнгын хороо, Улсын Их Хурлын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Үүнд:<br>- Хуулийн төслийн үзэл баримтлалыг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нараар 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр батлуулсан.<br>- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх, Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо зэргийг хийж, Хуулийн төслийн товч болон дэлгэрэнгүй танилцуулга гаргасан.<br>- Хуулийн төсөл 19 яамд, төрийн болон төрийн бус | 2024 оны 3-6 сар | 100 % |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | байгууллагаас санал авч, үндэслэл бүхий саналыг тусгасан.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Хуралдааны 13 дугаар тэмдэглэл гарсан.<br>- Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан. | | |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.<br>“Эмч нарын их хурал зохион байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх. | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 0% | Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | “Эмч нарын их хурал зохион байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, боловсруулан танилцуулгын хамт Эрүүл мэндийн сайдын 2024 оны 05 сарын 30-ны өдрийн 1а/2330 тоот албан бичгээр яамдуудаас санал авсан. Тус тогтоолын төслийг Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү тогтоолын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Монголын Эмч нарын VII их хурал” -ыг 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан. | 5-6 сар | 100 % |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. | Улсын Их Хурлын тогтоол | 0% | Нийгмийн бодлогын | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн | | |

96

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан "Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" тогтоолын төслийг боловсруулах. | | | байнгын хороо болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан Дотоодын эм (уламжлалт эм), биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Монгол Улсын Их Хурлын "Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" тогтоолын төсөл боловсруулж, Нийгмийн бодлогын байнгын хороо, УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 71 дугаар тогтоолоор баталсан. | 2024.4-6 сар | 100 % |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.<br>2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлээр БИБ-ний тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонтой холбогдуулан Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулах Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай | Хуулийн үзэл баримтлал батлуулах | 0% | Хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл боловсруулах. | Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулах Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах чиглэлээр ажлын хэсгийн хуралд 3 удаа оролцож ажилласан, Эрүүл мэндийн сайдын албан бичгээр 2 удаа санал боловсруулан хүргүүлж үзэл баримтлал болон хуулийн төслийг хамтран бүрэн боловсруулж дууссан. Хуулийн үзэл баримтлал батлуулах явцад Улсын Их Хурлын 2024 оны 06 сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль | 2024.03.сар-2024.06 сар | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах. | | | | /Шинэчилсэн найруулга/-ийг эцэслэн баталсан, уг хуулиар биологийн идэвхт бүтээгдэхүүнтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлсэн тул Эрүүл мэндийн сайдын 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 1а/2498 тоот албан бичгээр үзэл баримтлалыг батлах шаардлагагүй гэж үзэж холбогдох материалыг буцаан хүргүүлсэн. | | |

**Гурав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдах. | Гэрчилгээ | - | Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна. | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 3 сарын 11 өдрийн А/23 дугаар тушаалаар Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2024 оны 03 сарын 18-наас 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хүртэл хугацаанд суралцах хуваарийн сургалтад хамрагдаж 4 хичээлээр 8 кредит судалсан. Гэрчилгээний дугаар R2254 | 3-7сар | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2. | Арга хэмжээ 2. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажлыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмших. | Мэдлэг чадвар дээшилсэн байна. | - | - | 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хууль зүй дотоод хэргийн яаманд “Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад анхаарах асуудал”, “Захиргааны хэм хэмжээний төсөл боловсруулахад анхаарах асуудал”, “Хөгжлийн бодлого төлөвлөлт” гэсэн сэдвийн хүрээнд сургалтад хамрагдсан. | 8-11 сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын хууль эрх зүйн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Ганхуягийн Түвшинбаяр /......................... / 2024.12.05

*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Оюунсүрэн / ......................... / 2024.12.10

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*